



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/10

Мандалговь

Зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2023 оны 05 дугаар сарын 04–ний өдрийн 07 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг Хөөт-3 чулуун нүүрсний уурхай “Хуучин андууд” ХХК-ний хүн амын унд ахуйн хэрэгцээнд 3840 шоо метр, Ногоон байгууламж, зам талбайн усалгааны зориулалтаар 14515,2 м³/жил усыг 1 жилийн хугацаагаар ашиглахыг “Хуучин андууд” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. “Хуучин андууд” ХХК-ний ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, ажиллахыг усны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Цэрэнсугир)-т үүрэг болгосугай.

3. Монгол Улсын “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Баянжаргалан сумын Төрийн сан банкны дансанд тушаах, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дундговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг “Хуучин андууд” ХХК-ны захирал (А.Элбэгсайхан)-д үүрэг болгосугай.

4. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг “Хуучин андууд” ХХК-ны захирал (А.Элбэгсайхан)-д даалгасугай.



ДАРГА

Н.ГАНТУЛГА

Tuhsaal A

482301040